



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2015 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/382

Мөрөн


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "е" дахь заалт, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын шагайн хорооноос Говь-Алтай аймгийн төв Алтай хотод зохион байгуулсан Баруун бүсийн аймгуудын зөвлөгөөн, тэмцээнд оролцох баг тамирчдын унааны зардал 682000 төгрөг, "Иргэндээ ээлтэй аймаг" сэтгүүлийн тээврийн зардал 300000 төгрөгийг олгосугай.

2. Шаардагдах 982000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР